

ОНГОН СУМЫН ИТХ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 09 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид 1 удаа хуралдаж багийн Иргэдийн нийтийн хурлын товыг зарлалаа.

Аймгийн засаг даргын А/548 дугаар захирамжийг үндэслэн Сумын засаг даргын захирамжаар 2021 оны II ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагын ажлыг зохион байгуулах комиссыг томилж, бэлтгэл ажлыг хангасан.

Төрийн албаны зөвлөл, цэргийн штабаас ирүүлсэн хугацаатай 2 судалгааг заасан хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг хэрэгцээт үед нь тогтмол гарган өгч байна.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгч байна.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:

Тамгын газар, ИТХ-д шинээр томилогдсон 2 алба хаагчид ажлын байрны сургалт зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журам, тогтоолыг судлуулсан.

Улсын онцгой комиссын Шуурхай штабын даргын 2021 оны “Коронавирус халдвар батлагдсан болон сэжигтэй тохиолдолоор нас барсан хүнийг оршуулах үйл ажиллагаанд мөрдөх түр заавар”-ын дагуу Сумын онцгой комиссын даргын захирамжийг боловсруулж гаргасан.

Сумын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө, сумын 2021оны хөгжлийн төлөвлөгөөний

хэрэгжилтэд хяналт хийж, гүйцэтгэлийг хангах үүрэг чиглэлийг холбогдох албан тушаалтнуудад хугацаатай мэдэгдэх хуудсаар өгсөн.

Дөрөв.Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Монгол Улсын БШУЯ-ны сайд, Эрүүл мэндийн яамны сайдын хамтарсан А/292, А/525 дугаар тушаалыг үндэслэн 2021-2022 оны хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааг журмын дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримтлан хэвийн явуулж байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны сайдын “Төлөвлөгөө баталж хээргжүүлэх тухай” А/190 дүгээр тушаалын 3.5 дахь заалтын дагуу сурагчдын эзэмшвэл зохих агуулгын хоцрогдлыг тодорхойлох зорилгоор “Оношлогоо үнэлгээ” зохион байгуулах ажлыг амжилттай зохион байгуулсан. Тус шалгалтанд 2-12 дугаар ангийн 219 сурагч, түүвэрлэн орж, 24 багш, удирдах ажилтан, 60 эцэг, эх хамрагдаж, үндэсний хэмжээний сурлагын хоцрогдолыг арилгахад хамрагдсан нь шинэлэг ажил болсон.

Дэлхийн Зөн олон улсын байгууллагын 100 сая төгрөгийн санхүүжилтээр Хичээлийн I байрыг шинээр барьж, 10 суултууртай орчин үеийн стандартын бие засах өрөөг 09 дүгээр сарын 06-ны өдрөөс ашиглалтад оруулсан.



Сургуулийн Үйлдвэрчний эвлэл, сургуулийн захиргаа хамтран багш, ажилчдын дархлааг дэмжих, хичээлийн бэлтгэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор 67 багш ажилчинд 1.658.000 төгрөгийн үнэ бүхий бичгийн цаас, маск, 20 ш уут бүхий хайрцаг чацаргана өгсөн.



БШУЯ-ны сайд, Эрүүл мэндийн яамны сайдын хамтарсан А/292, А/525 дугаар тушаалыг үндэслэн хүүхдийн цэцэрлэгийн 2021-2022 оны хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааг журмын дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримтлан, танхимаар болон зайн хэлбэрээр хэвийн явуулж байна.

Хүүхдийн хүнсэнд эрүүл хүнс оруулах, хүнсний ногоо тарьж хэрэглэхийн ач тусыг хүүхдэд мэдрүүлэх зорилгоор багш ажилчид төмс, улаан лооль, сонгино, өргөст хэмх, хулуу нийт 50 кг ногоо тариалж, хүүхдүүдийн хамт хураан авч, хүнсний ногоотой танилцуулах ажил зохион байгуулсан.

Багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, вакцинжуулалтын судалгааг гаргасан.

Хүүхдүүдэд эрүүл мэндийн төвтэй хамтран үзлэг хийж, танхимаар хичээллэж байгаа 57 хүүхдийг цагаан хорхойн, 49 хүүхдийг томуугаас сэргийлэх вакцинд хамруулсан.

Цэцэрлэгийн тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд гадна хаалгыг шинэчилж, цэцэрлэгийн гадна тал, хашаа, тоглоомын талбайн өнгийг сэргээж урсгал засвар хийсэн.

Соёлын төвөөс “Соёлын ажилтны өдөр”-ийг тохиолдуулж “Гэрэл зураг түүх өгүүлнэ” цахим зургийн үзэсгэлэн гаргаж, байгууллагын цахим хуудсаар орон нутгийн иргэдэд хүргэсэн.

Мөн соёлын төвийн алба хаагчдын дунд “Бүтээлч өдрүүд” 14 хоногийн аяныг зохион байгуулж, идэвх санаачилгатай ажиллаж дуу бичлэгийн өрөөг шинээр тохижуулсан алба хаагчийг 100000 төгрөгөөр урамшуулсан.

Нийгмийн хамгаалал, халамжийн чиглэлээр 09 дүгээр сард дараах ажлуудыг хийсэн:

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төсөлд 1 иргэн

- Орон нутгийн оролцоонд түшиглэсэн буцалтгүй төсөлд 2 өрх
- Ногоон байгууламжийн нийтийг хамарсан ажилд 10 иргэн
- Малжуулах төсөлд 1өрх
- Нүдний үзлэг, шил тааруулахад 18 ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3
- Төрд харьяалалгүй ахмадын хүндэтгэлд 236 хүнийг тус тус хамруулав.

Сумын дулааны шугам засварын ажлын тендерийг хууль, журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллага ажлаа эхлүүлсэн.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу уурын зуухны 4 тогоо, янданг хөөлж, шугамд ус дүүргэлт, шахалт хийж халаалт өгөх бэлтгэлийг шалгаж, бэлэн байдлыг хангасан. Тал булгийн уурхайгаас 135 тн нүүрс татаж байгууллага, ААН-дэд халаалтыг 10 дугаар сарын 01-нээс өгөх бэлтгэл бүрэн хангагдсан.



Мөн эрүүл мэндийн төвтэй хамтран ажилчдаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.



Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд тамгын газраас хадлангийн 3 салааг томилон ажиллуулж, 140 тн байгалийн хадлан бэлтгээд байна.

Өвс, тэжээлийн нөөцийг хадгалах агуулахыг 110 сая төгрөгөөр барьж, улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.

Хөдөө аж ахуйн дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар 114 сая төгрөгөөр 80 трактор, хадуур, тармуур, боогч авсан, мөн нэмэлтээр Пад трактор, тармуурыг авч албанд ашиглаж байна.

Өөрсдийн хүчээр 12 тн төмс, 2 тн хүнсний нарийн ногоо тариалж, хурааж авсан.

Мал угаалгын 4 бүлэг ажиллаж угаалгын ажлыг зохион байгуулсан.

Хуц, ухнад бурцелёзын шинжилгээ хийхээр бэлтгэлийг хангасан.

Охин төл/хурга, ишиг, тугал, унага/-д бурцелёзын тарилга хийгдсэн.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХЭЗ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ